



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БНА-202/001/НА-СТА-ЗГТС

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: М.Алтантуяа Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn Аудитор: Н.Батчимэг Утас: 91113253 Цахим хаяг: batchimegn@audit.gov.mn
Баянхонгор 2026 оны 02 дугаар сарын 23	

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement\_bayankhongor@audit.gov.mn

2026.02.23 № 2/29

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г **Хязгаарлалттай дүгнэлт** Г

БАЯНХОНГОР АЙМГИЙН ХӨДӨЛМӨР  
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ГАЗРЫН ДАРГА Э.ЭНХТӨР ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

#### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Борлуулалтын дэмжлэг үзүүлэх зардал, хөдөлмөрийн салбарын ажилтнуудын сургалтын зардлаас зориулалт бусаар хөрөнгө зарцуулсан
- Хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний гэрээг дүнгээгүй
- Баримтын бүрдэл дутуу бараа материалыг тайланд тусгасан
- Зарим гүйлгээг анхан шатны баримтгүй хийсэн
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчин шууд худалдан авалт хийсэн зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухайн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 6.4.8-т "Төсвийг

6426050082

/2026 он/1. бичиг хэрэг/тоот/2. а4-  
албан тоот.docx

зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 16.5.5-т “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, заалтыг тус тус зөрчсөн, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйл 10.2-т “Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно”, МУЗГ-ын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны 02 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар”-ыг тус тус зөрчсөн, УСНББОУС-1 санхүүгийн тайлангийн толилуулга, УСНББОУС-12 бараа материал, санхүүгийн тайлангийн “Оршин байх”, “Тохиолдсон байх”, “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Иж бүрэн байх”, “Үнэлгээ ба хуваарилалт”, “Ангилал” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

#### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас тайлант онд 166 иргэнд 1,270,000.0 мянган төгрөгийн зээлийг олгосон байна.

#### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Ажил мэргэжлийн чиг баримтжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ, ажилд зуучлах үйлчилгээнд тайлант онд 3.680.0 мянган төгрөгийн 184 ширхэг бичгийн цаас, 1,929.0 мянган төгрөгийн 94 ширхэг өнгөт хор, 6,920.0 мянган төгрөгийн 147 ширхэг принтерийн хор зарцуулсан нь төсвийг хэмнэлтгүй, үрэлгэн зарцуулсан байна.

### **Бусад асуудал**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Баянхонгор аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 27 зорилтын 90 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, хэрэгжилтийг 98.2 хувьтай тайлагнасан байна.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР  Б.МӨНХБАТ



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>4,260,362,819.00</u></b>	<b><u>4,052,393,475.32</u></b>
33	<b>АВЛАГА</b>	4,260,362,819.00	4,052,393,475.32
335	<b>Бусад авлага</b>	4,260,362,819.00	4,052,393,475.32
3351	Байгууллагаас авах авлага	-	20,600,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	4,260,362,819.00	4,031,793,475.32
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>4,260,362,819.00</u></b>	<b><u>4,052,393,475.32</u></b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>5,940,000.00</u></b>	<b><u>119,438,337.00</u></b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	5,940,000.00	119,438,337.00
413	<b>Өглөг</b>	5,940,000.00	119,438,337.00
4136	<b>Бусад өглөг</b>	5,940,000.00	119,438,337.00
41361	Байгууллагад төлөх өглөг	5,940,000.00	66,278,337.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		53,160,000.00
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>4,254,422,819.00</u></b>	<b><u>3,932,955,138.32</u></b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	4,254,422,819.00	3,932,955,138.32
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	4,254,422,819.00	3,932,955,138.32
51210	Өмнөх үеийн үр дүн	2,752,202,147.00	4,260,362,819.00
51220	Тайлант үеийн үр дүн	1,502,220,672.00	(327,407,680.68)
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>4,260,362,819.00</u></b>	<b><u>4,052,393,475.32</u></b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b><u>3,318,532,000.00</u></b>	<b><u>1,449,240,600.00</u></b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b><u>39,072,000.00</u></b>	<b><u>80,902,800.00</u></b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	39,072,000.00	80,902,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	39,072,000.00	80,902,800.00
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	39,072,000.00	80,902,800.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b><u>3,279,460,000.00</u></b>	<b><u>1,368,337,800.00</u></b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	3,279,460,000.00	1,368,337,800.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	3,279,460,000.00	1,368,337,800.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b><u>1,810,371,328.00</u></b>	<b><u>1,776,648,280.68</u></b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b><u>1,810,371,328.00</u></b>	<b><u>1,776,648,280.68</u></b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	111,935,505.00	45,313,102.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	111,935,505.00	45,313,102.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	111,935,505.00	45,313,102.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,698,435,823.00	1,731,335,178.68
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	831,226,880.00	560,256,159.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	831,226,880.00	560,256,159.00
2135	<b>Төсвийн захирагчдаас олгосон</b>	867,208,943.00	1,171,079,019.68

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан			
	<b>санхүүжилт, шилжүүлэг</b>		
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	867,208,943.00	1,171,079,019.68
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>1,508,160,672.00</b>	<b>(327,407,680.68)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>1,508,160,672.00</b>	<b>(327,407,680.68)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>3,452,815,521.00</b>	<b>1,449,240,600.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>173,355,521.00</b>	<b>80,902,800.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	173,355,521.00	80,902,800.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	173,355,521.00	80,902,800.00
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	39,072,000.00	80,902,800.00
120004 3	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	134,283,521.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,279,460,000.00</b>	<b>1,368,337,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	3,279,460,000.00	1,368,337,800.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	3,279,460,000.00	1,368,337,800.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>4,054,371,328.00</b>	<b>2,947,809,943.68</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,054,371,328.00</b>	<b>2,947,809,943.68</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>111,935,505.00</b>	<b>44,618,254.00</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	111,935,505.00	44,618,254.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	111,935,505.00	44,618,254.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,942,435,823.00</b>	<b>2,903,191,689.68</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	3,075,226,880.00	1,732,112,670.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,075,226,880.00	1,732,112,670.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	867,208,943.00	1,171,079,019.68
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	867,208,943.00	1,171,079,019.68
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>(601,555,807.00)</b>	<b>(1,498,569,343.68)</b>
<b>14</b>	<b>Бусад эх үүсвэр</b>	601,555,807.00	1,498,569,343.68
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	601,555,807.00	1,498,569,343.68
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(601,555,807.00)</b>	<b>(1,498,569,343.68)</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан** (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	4,254,422,819.00	0.00	4,254,422,819.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	4,254,422,819.00	0.00	4,254,422,819.00
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	4,254,422,819.00	0.00	4,254,422,819.00
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	4,254,422,819.00	0.00	4,254,422,819.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	5,940,000.00	0.00	5,940,000.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	4,260,362,819.00	0.00	4,260,362,819.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-327,407,680.68	0.00	-327,407,680.68
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	3,932,955,138.32	0.00	3,932,955,138.32

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан** (төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	845,070,000.00	845,070,000.00	-	100.0
12	Татварын бус орлого	845,070,000.00	845,070,000.00	-	100.0
120	Нийтлэг татварын бус орлого	845,070,000.00	845,070,000.00	-	100.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	828,570,000.00	828,570,000.00	-	100.0
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	16,500,000.00	16,500,000.00	-	100.0
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,984,837,800.00	1,776,730,924.00	208,106,876.00	89.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,984,837,800.00	1,776,730,924.00	208,106,876.00	89.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	47,910,000.00	44,618,254.00	3,291,746.00	93.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	47,910,000.00	44,618,254.00	3,291,746.00	93.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	47,910,000.00	44,618,254.00	3,291,746.00	93.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,936,927,800.00	1,732,112,670.00	204,815,130.00	89.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,936,927,800.00	1,732,112,670.00	204,815,130.00	89.4
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,936,927,800.00	1,732,112,670.00	204,815,130.00	89.4

**Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан**

8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	1,139,767,800.00	931,660,924.00	208,106,876.00	81.7
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,139,767,800.00	931,660,924.00	208,106,876.0 0	81.7
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	1,139,767,800.00	931,660,924.00	208,106,876.00	81.7

### **3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 42,458.0 мянган төгрөгийн 2 алдаа илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

1. Анхан шатны баримт хангалтгүй, тухайн хөтөлбөр хэрэгжсэн эсэх нь тодорхой бус, нотлогдохгүй байхад 21,858.0 мянган төгрөгийн өр төлбөрийг санхүүгийн тайланд бүртгэж өглөгөөр тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 5.1.4 дэх "үнэн зөв байх", санхүүгийн тайлангийн "Үнэлгээ ба хуваарилалт", "Тохиолдсон байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна. Иймд 21,858.0 мянган төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд бууруулан залруулав.

2. "Эвт шүр" ХХК-тай 2025.09.04-ний өдөр 8,000.0 мянган төгрөгийн бүтээгдэхүүний зураг авалт хийх гэрээг 1 сарын хугацаатай байгуулсан ба зураг авалт хийгдээгүй байхад 2025.09.30-ны төлбөрийг бүрэн шилжүүлсэн, мөн "Мөнхийн үсэг" ХХК-тай 2025.09.04-ний өдөр нэг бүр нь 21.0 мянган төгрөгийн үнэтэй 600 ширхэг сэтгүүл хийх гэрээг байгуулж 2025.09.30-ны өдөр 12,600.0 мянган төгрөгийг бүрэн шилжүүлсэн бөгөөд зураг авалт, сэтгүүл нийлүүлэгдээгүй байхад санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэсэн заалтыг зөрчсөн байна. Иймд 20,600.0 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд бүртгэн залруулав.

Аудитаар нийт 153,903.1 мянган төгрөгийн 11 зөрчил<sup>1</sup> илэрснээс, 21,465.0 мянган төгрөгийн 5 төлбөрийн акт тогтоож, 132,438.1 мянган төгрөгийн 5 албан шаардлага, сахилгын хариуцлага тооцох 1 албан шаарлага хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлийн 153,903.1 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон 11,791.2 мянган төгрөгийн гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшнээс 142,111.9 мянган төгрөгөөр их тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 3.1 Төлбөрийн акт

3.1.1. Ажилд зуучлах үйлчилгээний маягт 24,536.0 мянган төгрөгөөр хөтөлбөрийн зардлаас худалдан авсан байхад 5,480.0 мянган төгрөгийн маягтыг НББ-д орлогоор бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 14 дүгээр зүйлийн 14.4 дэх "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Бүртгээгүй маягтын зардал 5,480.0 мянган төгрөгийг 2026 оны төсвөөс төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.1.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд борлуулалтын дэмжлэг үзүүлэх зардлаас 2,660.0 мянган төгрөгийг бэлгийн багцад зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зориулалт бусаар зарцуулсан 2,660.0 мянган төгрөгийг дарга, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн нараар төсөвт төлүүлж төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.1.3. "Элбэг саран" ХХК-д 2025.04.29-ний өдөр 1,500.0 мянга, "Бтоз" ХХК-д 2025.05.09-ний өдөр 1,000.0 мянга нийт 2,500.0 мянган төгрөгийг 1000 ширхэг брошурын үнэнд шилжүүлсэн ба 1000 ширхэг брошуртыг хүлээж аваагүй, баримтад өмнөх жилийн брошур хавсаргасан, хэрхэн тараасан нь тодорхойгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: брошурын үнэнд шилжүүлсэн 2,500.0 мянган төгрөгийг дарга, мэргэжлийн чиг баримжаа, хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн нараар төлүүлж төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.1.4. Хөдөлмөрийн салбарын ажилтнуудын сургалтын зардлаас ХХҮГ-ын албан хаагчдыг чадавхжуулах "Төрийн үйлчилгээний ёс зүй, байгууллагын соёл ба хамтын ажиллагаа" сургалтын зардалд "Далай ээж" ХХК-д 2026.06.25-ны өдөр хоолны зардалд нэг бүр нь 73.0 мянган төгрөгийн 25 хүний 1,825.0 мянган төгрөгийг шилжүүлж зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зориулалт бусаар зарцуулсан 1,825.0 мянган төгрөгийг холбогдох албан хаагчдаар төлүүлж төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.1.5. Борлуулалтын дэмжлэг үзүүлэх зардлаас "Ному ган медиа" ХХК-д 2025.09.30-ны өдөр видео контентын зардалд 9,000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн ба тус контент хийгдээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-т "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, УИХ-аас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн ИТХ, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх", Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын "Ному ган медиа" ХХК-тай 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр байгуулсан "Ажил гүйцэтгэх гэрээ"-ний 2.1, 3.2, 4.5, 5.5 дахь хэсгийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хийгдээгүй контентын үнэнд шилжүүлсэн 9,000.0 мянган төгрөгийг дарга, хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн нараар төлүүлж төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

## **3.2 Албан шаардлага**

3.2.1. Ажил мэргэжлийн чиг баримтжаа олгох, зөвлөгөө өгөх, ажилд зуучлах үйлчилгээний маягтын зардалд тайлант онд үнийн санал аваагүй, гэрээ байгуулаагүйгээр иргэн Т.С-ийн дансанд-24,536.0 мянган төгрөг шилжүүлсэн, мөн бичиг хэргийн зардалд 23,384.6 мянган төгрөгийг зарцуулсан ба тендер зарлалгүйгээр шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйл 10.2-т "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн

дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно", МУЗГ-ын 2024.01.03-ны 02 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлант оны эхэнд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлан, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжүүлэн худалдан авах ажиллагаа зохион байгуулж байх албан шаардлагыг өгөв.

3.2.2. Ажил мэргэжлийн чиг баримтжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ, ажилд зуучлах үйлчилгээнд 3,680.0 мянган төгрөгийн 184 ширхэг бичгийн цаас, 1,929.0 мянган төгрөгийн 94 ширхэг өнгөт хор, 6,920.0 мянган төгрөгийн 147 ширхэг принтерийн хор зарцуулсан нь төсвийг хэмнэлтгүй, үрэлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх", 15.2.4-т "цахим гарын үсэг, цахим шуудан ашиглах зэргээр албан бичиг боловсруулах, илгээх үйл явцыг хялбаршуулж бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хор, шуудан хүргэлтийн зардлыг хэмнэх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нөөцлөх шаардлагагүй бараа материал нөөцөлдөг байдлыг таслан зогсоож, цаашид Төсвийн тухай хууль болон Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэн төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах албан шаардлагыг хүргүүлэв.

3.2.3. "Тод шаглаа майнинг" ХХК-тай 2023.11.01-ний өдөр, "Элбата" ХХК-тай 2023.11.01-ний өдөр "Ажил олгогчид урамшуулал олгох тухай гэрээ" байгуулж гэрээний хугацаа 2024.11.01-ний өдөр дууссан байхад санхүүгийн тайланд өр төлбөрөөр тусгаагүй, тус 2 аж ахуйн нэгжид 30,800.0 мянган төгрөгийг 2025 оны төсвөөс олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.3-т "бүх өр төлбөр" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд өр төлбөрөөр тусгагдаагүй байхад тайлант оны төсвөөс өмнөх оны өр төлбөрийг барагдуулдаг байдлыг таслан зогсоож, цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлагыг хүргүүлэв.

3.2.4. Борлуулалтын дэмжлэг үзүүлэх зардлыг зөвхөн борлуулалтын цэгийн түрээсийн төлбөр болон урсгал зардал (цахилгаан, дулаан, интернэт гэх мэт)-д зарцуулахаар удирдамжид тусгасан байхад 20,588.5 мянган төгрөгийг "Намрын ногоон өдрүүд-2025" үзэсгэлэн худалдааны урсгал зардал, 7 зээлдэгчийг

Улаанбаатар хотод үзэсгэлэнд оролцуулах замын зардал болон бусад зардалд зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн “Тушаалын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” А/150 дугаар тушаалыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Борлуулалтын дэмжлэг үзүүлэх зардлыг зориулалтын дагуу зарцуулж байх, цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлагыг хүргүүлэв.

3.2.5. Борлуулалтын дэмжлэг үзүүлэх зардлыг зөвхөн борлуулалтын цэгийн түрээсийн төлбөр болон урсгал зардал (цахилгаан, дулаан, интернэт гэх мэт)-д зарцуулахаар удирдамжид тусгасан байхад 30 аж ахуйн нэгжийн зураг авалтад 8,000.0 мянга, сэтгүүлийн зардалд 12,600.0 мянган төгрөгийн зарцуулсан зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн “Тушаалын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” А/150 дугаар тушаалыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Борлуулалтын дэмжлэг үзүүлэх зардлыг зориулалтын дагуу зарцуулж байх, цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлагыг хүргүүлэв.

3.2.6. Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн 4 албан хаагч нь хийгдээгүй 12,600.0 мянган төгрөгийн сэтгүүл, 9,000.0 мянган төгрөгийн контент, 8,000.0 мянган төгрөгийн зураг авалтыг хийснээр тайлагнасан, бараа материалын тайланд контент, сэтгүүлийг орлого авч зарлагадсан, хийгээгүй сургалтыг хийснээр тайлагнаж 7,000.0 мянган төгрөгийг санхүүгийн тайланд авлагаар тусгасан байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.6-т “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилдаа хариуцлагагүй хандсан холбогдох 4 албан хаагчид сахилгын арга хэмжээг авах албан шаардлагыг хүргүүлэв.

### **3.3 Зөвлөмж**

3.3.1. Тайлант онд хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 26 иргэнд 100,000.0 мянга, ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 45 иргэнд 550,000.0 мянга, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 40 иргэнд 320,000.0 мянга, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хэгжүүлэх хөтөлбөрт 55 иргэнд 300,000.0 мянга, нийт 166 иргэнд 1,270,000.0 мянган төгрөгийн зээл олгосон, өмнөх оны хугацаа хэтэрсэн зээлийг шүүхэд шилжүүлсэн ба цаашид зээл хугацаа хэтрэх эрсдэлтэй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид зээлдэгч нартай зээл олгох зээлийн гэрээ байгуулахдаа гэрээг нотариатаар гэрчлүүлж, гэрээнд нотариатын мэдэгдэх хуудсаар болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаар хялбаршуулсан журмаар шийдвэрлүүлэх нөхцөлийг тодорхой тусгах замаар зээлийн эргэн төлөлтийг хангах, зээлийн хугацаа хэтрэх эрсдэлийг бууруулж ажиллах.

Аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг нотлох баримтын хамт Төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөг)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланд баримтаар нотлогдохгүй өр төлбөр тусгасан	1	21,858.0	-	-	1	21,858.0	1	21,858.0	-	-
Санхүүгийн тайланд авлагыг тусгалгүй орхигдуулсан	1	20,600.0	1	20,600.0	-	-	1	20,600.0	-	-
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>42,458.0</b>	<b>1</b>	<b>20,600.0</b>	<b>1</b>	<b>21,858.0</b>	<b>2</b>	<b>42,458.0</b>	<b>-</b>	<b>-</b>

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Ажил мэргэжлийн чиг баримтжаа олгох, зөвлөгөө өгөх, ажилд зуучлах үйлчилгээний маягтын зардалд тайлант онд үнийн санал аваагүй, иргэн Т.С-тай гэрээ байгуулаагүйгээр 24,536.0 мянган төгрөг шилжүүлсэн, мөн бичиг хэргийн зардалд 23,384.6 мянган төгрөгийг зарцуулсан ба тендер зарлалгүйгээр шууд худалдан авалт хийсэн байна.	1	47,920.6	-	-	1	47,920.6	-	-		

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Ажилд зуучлах үйлчилгээний маягтын зардалд 24,536.0 мянган төгрөгийг зарцуулж, 5,480.0 мянган төгрөгийн маягтыг орлогыг бүртгээгүй байна.	1	5,480.0	1	5,480.0	-	-	-	-		
Ажил мэргэжлийн чиг баримтжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ, ажилд зуучлах үйлчилгээнд 3.680.0 мянган төгрөгийн 184 ширхэг бичгийн цаас, 1,929.0 мянган төгрөгийн 94 ширхэг өнгөт хор, 6,920.0 мянган төгрөгийн 147 ширхэг принтерийн хор зарцуулсан нь төсвийг хэмнэлтгүй, үрэлгэн зарцуулсан байна.	1	12,529.0	-	-	1	12,529.0	-	-		
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд борлуулалтын дэмжлэг үзүүлэх зардлаас 2,660.0 мянган төгрөгийг бэлгийн багцад зориулалт бусаар зарцуулсан байна.	1	2,660.0	1	2,660.0	-	-	-	-		
"Тод шаглаа майнинг" ХХК-тай 2023.11.01-ний өдөр, "Элбата" ХХК-тай 2023.11.01-ний өдөр "Ажил олгогчид урамшуулал олгох тухай гэрээ"-г байгуулсан ба гэрээний хугацаа 2024.11.01-ний өдөр дууссан байхад санхүүгийн тайланд өр төлбөрөөр тусгаагүй, тус 2 ААН-д 30,800.0 мянган төгрөгийг 2025 оны төсвөөс олгосон байна.	1	30,800.0	-	-	1	30,800.0	-	-		
"Элбэг саран" ХХК-д 2025.04.29-ний өдөр 1,500.0 мянга, "Бтоз" ХХК-д 2025.05.09-ний өдөр 1,000.0 мянга нийт 2,500.0 мянган төгрөгийг 1000 ширхэг брошурын үнэнд шилжүүлсэн ба баримтад өмнөх жилийн брошур хавсаргасан, брошурыг хийлгэсэн	1	2,500.0	1	2,500.0	-	-	-	-		

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
эсэх нь баримтаар нотлогдохгүй, хэрхэн тараасан нь тодорхойгүй байна.										
Хөдөлмөрийн салбарын ажилтнуудын сургалтын зардлаас ХХҮГ-ын албан хаагчдыг чадавхижуулах "Төрийн үйлчилгээний ёс зүй, байгууллагын соёл ба хамтын ажиллагаа" сургалтын зардалд "Далай ээж" ХХК-д 2026.06.25-ны өдөр хоолны зардалд нэг бүр нь 73.0 мянган төгрөгийн 25 хүний 1,825.0 мянган төгрөгийг шилжүүлж зориулалт бусаар зарцуулсан байна.	1	1,825.0	1	1,825.0	-	-	-	-	-	-
Борлуултын дэмжлэг үзүүлэх зардлыг зөвхөн борлуулалтын цэгийн түрээсийн төлбөр болон урсгал зардал (цахилгаан, дулаан, интернэт гэх мэт)-д зарцуулахаар удирдамжид тусгасан байхад 20,588.5 мянган төгрөгийг "Намрын ногоон өдрүүд-2025" үзэсгэлэн худалдааны урсгал зардал, 7 зээлдэгчийг Улаанбаатар хотод үзэсгэлэнд оролцуулах тээврийн зардал болон бусад зардалд зарцуулсан зориулалт бусаар байна.	1	20,588.5	-	-	1	20,588.5	-	-		
Борлуулалтын дэмжлэг үзүүлэх зардлаас "Ному ган медиа" ХХК-д 2025.09.30-ны өдөр видео контентын зардалд 9,000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн ба тус контент хийгдээгүй байна.	1	9,000.0	1	9,000.0	-	-	-	-		
Борлуулалтын дэмжлэг үзүүлэх зардлыг зөвхөн борлуулалтын цэгийн түрээсийн төлбөр болон урсгал зардал (цахилгаан, дулаан, интернэт гэх мэт)-д зарцуулахаар удирдамжид тусгасан байхад 30 аж ахуйн нэгжийн зураг авалтад 8,000.0 мянга, сэтгүүлийн зардалд 12,600.0 мянган төгрөгийн	1	20,600.0	-	-	1	20,600.0	-	-		

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

зарцуулсан зориулалт бусаар зарцуулсан байна.	2	3	4	5	6	7	8	9	10	11
1										
Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн 4 албан хаагч нь хийгдээгүй 12,600.0 мянган төгрөгийн сэтгүүл, 9,000.0 мянган төгрөгийн контент, 8,000.0 мянган төгрөгийн зураг авалтыг хийснээр тайлагнасан, бараа материалын тайланд орлого контент, сэтгүүлийг авч зардлагадсан, хийгээгүй сургалтыг хийснээр тайлагнаж 7,000.0 мянган төгрөгийг санхүүгийн тайланд авлагаар тусгасан байна.	1	-	-	-	-	-	-	-	1	-
Тайлант онд хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 26 иргэнд 100,000.0 мянга, ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 45 иргэнд 550,000.0 мянга, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 40 иргэнд 320,000.0 мянга, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хэгжүүлэх хөтөлбөрт 55 иргэнд 300,000.0 мянга, нийт 166 иргэнд 1,270,000.0 мянган төгрөгийн зээл олгосон, өмнөх оны хугацаа хэтэрсэн зээлийг шүүхэд шилжүүлсэн ба цаашид зээл хугацаа хэтрэх эрсдэлтэй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-
<b>Дүн</b>	12	153,903.1	5	21,465.0	5	132,438.1	1	-	1	-

-----oOo-----